



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
Сүхбаатар аймаг дахь төрийн
аудитын газар

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД
ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТНУУДААС ТАВИХ ХЯНАЛТ
ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

АУДИТЫН НЭР: УЛСЫН ТӨСВИЙН 2023 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: СБА-2024/18-16-ШТА-ГА

Баруун-Урт 2024 он



Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Г.Даваа

Утас: 70518396 Цахим хаяг: davaag@audit.gov.mn

Аудитын менежер М.Нарантуяа

Утас: 70512123 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Ахлах аудитор Г.Оюунболд

Утас: 70512127 Цахим хаяг: oyunboldg@audit.gov.mn

Аудитор Э.Алтансүх

Утас: 70512127 Цахим хаяг: altansukhe@audit.gov.mn

Аудитор Б.Ганццэг

Утас: 70512127 Цахим хаяг: gantsetsegb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах
хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	4
БҮЛЭГ А. ЗАРИМ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНХҮҮЖИЛТИЙГ БОДИТ ГҮЙЦЭТГЭЛЭЭС ИЛҮҮ ОЛГОСОН БАЙНА.	5
<i>А.1. Архитектур төлөвлөлтийн даалгаврыг “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн дагуу боловсруулаагүй байна.</i>	<i>5</i>
<i>А.2. Төсөл арга хэмжээний төсөвт өртгийг улсын төсөвт бүрэн тусгаагүйгээс зарим төсөл арга хэмжээ удаашрах, дуусахгүй орхих эрсдэлүүд үүсэж байна.</i>	<i>6</i>
<i>А.3. Зарим төсөл арга хэмжээний бодит гүйцэтгэлийг 601.2 сая төгрөгөөр илүү дүнгээр баталгаажуулж, санхүүжилтийг олгожээ.</i>	<i>6</i>
БҮЛЭГ Б. УЛСЫН КОМИСС ХҮЛЭЭН АВСАН БАРИЛГУУДАД ДЭЭВРЭЭС УС ГООЖИХ, ДУЛААН АЛДАГДАЛ ИХТЭЙ БАЙХ ЗЭРЭГ ЗӨРЧИЛ НИЙЛЭГ ГАРЧ БАЙНА.	7
<i>Б.1. Гүйцэтгэгчээс шалтгаалж барилгын ажил гүйцэтгүүлэх гэрээг цуцлах нөхцөл байдал үүссэн 2 төсөл арга хэмжээ байна.</i>	<i>7</i>
<i>Б.2. Төсөл арга хэмжээний хэрэгжилттэй холбоотой зөрчил багагүй байгаа нь бүх шатны хяналт үр нөлөөгүй байгааг илтгэж байна.</i>	<i>10</i>
<i>Б.3. Хэрэгжүүлж дууссан төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаагүй байна.</i>	<i>11</i>
БҮЛЭГ В. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР БИЙ БОЛСОН ХӨРӨНГИЙН ТҮРЭЭСИЙН ОРЛОГЫН ТӨВЛӨРҮҮЛЭЛТИЙГ ЭС ТООЦВОЛ БАРИЛГЫН БАЙГУУЛАМЖИЙН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНҮҮД ТӨЛӨВЛӨСӨН ҮР ДҮНД ХҮРСЭН БАЙНА.	13
<i>В.1. Шинэ хөдөө төслийн хүрээнд бий болсон техник хэрэгслийн түрээсийн орлого бүрэн төвлөрөөгүй байна.</i>	<i>13</i>
<i>В.2. Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь хэрэгцээ шаардлагыг хангаж, төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна.</i>	<i>14</i>
Холбогдох байгууллагын санал:	16
Ирүүлсэн саналд өгсөн тайлбар:	16
ДҮГНЭЛТ: 22	
ЗӨВЛӨМЖ:.....	23
Үндэсний аудитын газарт хүргүүлж буй санал:	24

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АЗДТГ	Аймгийн засаг даргын тамгын газар
АИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
УИХ	Улсын Их хурал
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Хүснэгтийн жагсаалт

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Улсын төсвийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг данс бүртгэл	12
Хүснэгт 2	Шинэ хөдөө төслийн 6 багцын нэр, төсөвт өртөг	13

Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь зүйлийг үндэслэн мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоолын дагуу хийв.
Аудитын зорилт	Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг АИТХ, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэнэ.
Аудитын хамарсан хүрээ	Аудитад улсын төсвийн хөрөнгө оруулалтыг 2023 онд хэрэгжүүлсэн Төсвийн ерөнхийлөн захирагч болон тэдгээрийн харьяа байгууллагууд, захиалагчийн техник хяналт хэрэгжүүлэгч байгууллага болон зураг төслийн компаниуд, холбогдох бусад байгууллага, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан төсөл, арга хэмжээний төлөвлөлт, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ түүний хэрэгжилт, баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, олгосон санхүүжилт, эрх бүхий байгууллагуудаас хяналт хийсэн ажлын тайлан болон төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн хүрээнд аудитыг гүйцэтгэлээ.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа явуулах арга зүйг ашиглаж аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор Г.Даваа удирдаж, аудитын менежер М.Нарантуяа чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Оюунболд, аудитор Э.Алтансүх, Б.Ганцэцэг нар 2024 оны 01 сарын 22-ны өдрөөс 4 сарын 19-ний өдрийг хүртэлх хугацаанд аудитыг гүйцэтгэв.

БҮЛЭГ А. ЗАРИМ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНХҮҮЖИЛТИЙГ БОДИТ ГҮЙЦЭТГЭЛЭЭС ИЛҮҮ ОЛГОСОН БАЙНА.

А.1. Архитектур төлөвлөлтийн даалгаврыг “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн дагуу боловсруулаагүй байна.

1.1.1. Газар эзэмших эрхийн гэрчилгээ гараагүй байхад барилга барих зөвшөөрөл олгож байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 зүйлийн 3 дахь заалт “Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно:”, 13 зүйлийн 3.3 дахь “техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ” заалтыг зөрчсөн. Мөн Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-д “эрх бүхий байгууллагаас олгосон газрын зөвшөөрөл, зургийн даалгавар, норм, нормативын баримт бичиг, стандарт, технологийн даалгавар, тоног төхөөрөмжийн паспорт, техникийн нөхцөл, инженер хайгуулын судалгаанд үндэслэн боловсруулагдсан байх” гэж заасныг зөрчиж зураг төсөл боловсруулсан байна.

1.1.2. Зарим барилга байгууламжийн зураг төслийн ажлын даалгаврыг зөрүүтэй боловсруулснаас ажил орхигдож, хөрөнгө оруулалт үр ашиггүй болох эрсдэлийг бий болгож байна. Үүнд: Мал эмнэлгийн хяналт, ариутгалын пунктын зураг төсөвт зарим ажил орхисны улмаас дахин тендер зарласан, заалны бохир усыг гадагшлуулах хоолой зураг төсөвт тусгаагүй байна.

1.1.3. Захиалагч зам, барилгын ажлын төсөвт өртөгт норм, нормативын сангийн зардлыг санхүүжилтээс суутгаж, холбогдох хөгжлийн төвийн дансанд шилжүүлээгүй байна. Энэ нь “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.2.2.5-д “төсөл, арга хэмжээний техник, технологийн хяналтын зардал болох захиалагчийн хяналт, зохиогчийн хяналтын зардлыг захиалагчийн техник хяналтын дансанд, чанарын баталгаат хугацааны барьцаа буюу ашиглалтад тохируулах, зүгшрүүлэх хугацааны санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд, зураг төслийн үнэ, **нормчлолын сангийн зардлыг тус тусын дансанд** холбогдох гэрээ, баримт бичиг, акт зэргийг үндэслэн шилжүүлэх” гэж заасантай нийцэхгүй байна.

1.1.4. “Барилгын төсөв зохиох дүрэм”-ийн 5.10-т “Тоног төхөөрөмжийн зардалд тусгайлан бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зориулагдсан, барилгын хэвийн үйл ажиллагаа хангахад зориулагдсан барилга объектын бүрэлдэхүүнд орж угсрагдаж, технологийн процесст хэрэглэгдэх дараах тоног төхөөрөмжүүдийг тусгана. Эдгээрийг материалын зардлын тооцоонд тусгахгүй.” гэж заасан. Үүнд:

- Эргэлтийн болон өргөлтийн хугдгийн бүх төрлийн цахилгаан насос;
- Агаар сорох, оруулах бүх төрлийн цахилгаан сэнс;
- Ялтсан дулаан солилцуур;
- КТПН /гадна тавигдах трансформатор, иж бүрдэл, дэд станц/;
- Эрчим хүчний хуваарилах төхөөрөмж;
- Бохир ус цэвэрлэх ариутгах татуурга, агааржуулагчийн системийн төхөөрөмж;
- Хөргөлтийн тоног төхөөрөмж;

- Нүүрсээр галладаг нам даралтын болон нүүрс, цахилгаанаар хосолсон, дан цахилгаанаар ажилладаг халаалтын тогоо;
- Цахилгаан шат, урсдаг болон өргөдөг шат, тэдгээрийн тоног төхөөрөмж;
- Дээрх үйл ажиллагааны чиглэлд багтах бусад тоног төхөөрөмж;
- Усны нөөцийн сав;
- Сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж;
- Дизель генератор;
- Өндөр технологи, ухаалаг удирдлагын системтэй тусгай зориулалтын барилга байгууламжийн тоног, төхөөрөмж, тоноглол.

1.1.5. Дээрх журмын заалтыг мөрдөлгүй зарим төсөл арга хэмжээний хүчний хувьд вентиллятор, нөөцийн сав, насос, видео төхөөрөмж, агаарын дулаан хөшиг, трансформатор гэх мэт тоног төхөөрөмжийг материалын зардлын тооцоонд тусгаж, ашгийн 15 хувиар төсөвт өртгийг өсгөсөн зөрчил илэрсэн. Тодруулбал 11 төсөл арга хэмжээний хувьд 198.4 сая төгрөгийн үнийн дүн бүхий 51 ширхэг тоног төхөөрөмжийг материалын зардлын тооцоонд тусгаж, тухайн төсөл арга хэмжээнүүдийн ашиг нийтдээ 29.8 сая төгрөгөөр нэмэгдэж, улмаар уг дүнгээр төсөвт өртөг өссөн байна.

1.1.6. Барилга, байгууламжийн архитектур төлөвлөлтийн даалгаварт барилга байгууламжийн хэмжээ, өндөр, давхрын тоо, нүүр тал буюу фасадын зонхилох өнгө, дээвэр, тагтны хашлага, хаалт, материалын талаар тодорхой зааж өгөөгүй нь /Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм/-ийн 3.3.2, 3.3.6 дахь заалттай нийцээгүй байна.

A.2. Төсөл арга хэмжээний төсөвт өртгийг улсын төсөвт бүрэн тусгаагүйгээс зарим төсөл арга хэмжээ удаашрах, дуусахгүй орхих эрсдэлүүд үүсэж байна.

1.2.1. Төсөл, арга хэмжээний төсөвт өртөг улсын төсөвт бүрэн тусгагдаагүйн улмаас барилгын ажил удаашрах байдал үүссэн байна. Тухайлбал: Дарьганга сумын хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлын гадна шугам сүлжээний төсөвт өртөг улсын төсөвт батлагдаагүйн улмаас ажил удааширсан. Мөнххаан сумын иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилгын гадна ажлын төсвийг улсын төсөвт тусгаагүйгээс орхисноор орон нутгийн хөгжлийн сангийн 321.0 сая төгрөгийн хөрөнгөөр санхүүжүүлж гүйцэтгэсэн байна.

A.3. Зарим төсөл арга хэмжээний бодит гүйцэтгэлийг 601.2 сая төгрөгөөр илүү дүнгээр баталгаажуулж, санхүүжилт олгожээ.

1.3.1. Дарьганга зусланг орчин үеийн стандартад нийцсэн амралт, аялал жуулчлалын цогцолбор болгон шинэчлэх төсөл арга хэмжээний хооллох танхимын барилгын суурийн ажил, 20 ортой бүлгийн 4 байрны хана, хамар хана, дээврийн болон хаалга, цонхны ажлын санхүүжилтийг бодит гүйцэтгэлээс 77.8 сая төгрөгөөр илүү олгосон.

1.3.2. Дарьганга сумын 150 ортой цэцэрлэгийн барилгын 2-р давхрын дотор хана, таац, багана, дам нуруу тэгшлэх, шавардах ажил, 1-р давхрын таац, дам нуруу тэгшлэх ажил хийгдээгүй байхад 26.2 сая төгрөгийн санхүүжилт, мөн бодит гүйцэтгэл 69.7 хувьтай байхад үнийн өсөлтийн нэмэгдэл 377.2 сая төгрөгийг бодит

гүйцэтгэлд үндэслэлгүйгээр 100 хувь олгож, 114.3 сая төгрөгийн санхүүжилтийг урьдчилж шилжүүлэн, нийт 140.5 сая төгрөгийн санхүүжилт илүү олгосон байна.

1.3.3. Спорт цогцолборын барилга төсөл арга хэмжээний ногоон байгууламж, талбайн тохижилтын ажлын санхүүжилтийг бодит гүйцэтгэлээс 95.0 сая төгрөгөөр илүү олгосон байна. Соёл амралтын хүрээлэн төсөл арга хэмжээний 9.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй гэрээний ажлын хувьд дугуй, гүйлтийн замын ажил, авто зогсоолын талбайн ажлын санхүүжилтийг бодит гүйцэтгэлээс 288.3 сая төгрөгөөр илүү олгожээ.

1.3.4. Сумын төвийн хатуу хучилттай авто зам 3.6 км, 4 замын уулзвар /Сүхбаатар, Мөнххаан сум/-ын хувьд 460 метр замын хашлага болон явган хүний замын хашлага болон 120 метр замын асфальтан хучилт хийгдээгүй байхад гүйцэтгэлийг баталгаажуулж, санхүүжилтийг олгосон байна.

1.3.5. Барилгын ажлын санхүүжилтийг бодит гүйцэтгэлээр олгохгүй байгаа нь “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.8.12-д “Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлээр олгох бөгөөд урьдчилгааг дараах тохиолдолд олгоно” гэж заасныг зөрчсөн тул буруутай албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлжээ.

БҮЛЭГ Б. УЛСЫН КОМИСС ХҮЛЭЭН АВСАН БАРИЛГУУДАД ДЭЭВРЭЭС УС ГООЖИХ, ДУЛААН АЛДАГДАЛ ИХТЭЙ БАЙХ ЗЭРЭГ ЗӨРЧИЛ НИЙТЛЭГ ГАРЧ БАЙНА.

Б.1. Гүйцэтгэгчээс шалтгаалж барилгын ажил гүйцэтгүүлэх гэрээг цуцлах нөхцөл байдал үүссэн 2 төсөл арга хэмжээ байна.

2.1.1. Барилга угсралтын дуусаагүй дараах 2 төсөл арга хэмжээний хувьд зураг төслийн дагуу барилгын үе шатны ажлыг хийж гүйцэтгээгүй байна. Үүнд:

- Түвшинширээ сумын 100 ортой дотуур байрны барилгын дээврийг мембран материалар хучих байтал хар цаасаар хучсан байна. Барилгын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д “Барилгын материал, бүтээгдэхүүнийг барилгын ажлын явцад захиалагч, гүйцэтгэгчийн хүсэлтийг үндэслэн зураг төсөл зохиогчийн шийдвэрээр өөрчилнө” гэж заасныг зөрчин барилгын дээврийн ажлын материалыг өөрчилж, зураг төслийг дагуу гүйцэтгээгүй.
- Баруун-Урт сумын 960 хүүхдийн суудалтай 5-р сургуулийн барилгын коридорт чулуун шал хийх байтал шаланд хулдаас дэвсэж, материалын үнийн өсөлтийн нэмэлт санхүүжилтийг чулуун шал хийснээр тооцож олгосон. Мөн барилгын баруун, зүүн талаар явганы замын ажлын оронд сургуулийн өмнөх талбайд бетон цутгалтын ажлыг хийж, зураг төслийг мөрдөөгүй байна.

2.1.2. Дээрх 2 барилгын зарим үе шатны ажлыг зураг төслийн дагуу хийж гүйцэтгээгүй нь Барилгын тухай хуулийн 40.1.17-д “барилгын ажлын явцад зураг төсөл өөрчлөгдсөн бол гүйцэтгэлийн зураг төсөл боловсруулж баталгаажуулах” гэж заасныг зөрчсөн тул өөрчлөлтийн төсөв хийлгэж, зөрүү төсвийг чанарын баталгаат хугацааны барьцаа хөрөнгөөс суутгах албан шаардлага хүргүүлжээ.

2.1.3. Мөн Зөрчлийн тухай хуулийн 12.1 дүгээр зүйлийн 3-т “Барилгын ажлын явцад төсөлд заасан тухайн барилга байгууламжийн барилгын ажлын талбайн хэмжээ, хил хязгаар, зураг төсөл, барилга архитектурын эх загвар /эскиз/ зураг, барилгын материалыг дур мэдэн өөрчилсөн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэж заасан тул эрх бүхий байгууллага, албан тушаалтанд дээрх зөрчлийн мэдээллийг албан бичгээр хүргүүлээ.

2.1.4. Мөн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт барилгын хяналтын улсын байцаагчийн орон тоо байгаа боловч ажиллах боловсон хүчин байхгүй байгаа нь Барилгын тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан техникийн улсын хяналт төсвийн хөрөнгөөр баригдаж буй барилга, байгууламжуудад хэрэгжихгүй байна.

2.1.5. Барилгын ажил дуусаж, ашиглалтад хүлээн авсан боловч барилгын ажил чанаргүй, комиссоос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй дараах төсөл арга хэмжээнүүд байна. Үүнд:

- Наран сумын сургуулийн 50 ортой дотуур байрны барилгын цонхонд чулуун тавцан хийх ёстой боловч хуванцар тавцан хийсэн, хагарч эвдэрсэн, цонхны амлагаагаар сийгж, дулаан алдагдал ихтэй, өвлийн хүйтэнд өрөөний температур 7-9 градус байдаг, борооны ус гоожсон, аваарын гарц буюу зүүн талын тагтны вакумын хаалга, цонх сийгүүртэй, дулаан их алддаг. Гал тогооны агааржуулагч ажилладаггүй, үүдний хэсгийн гадна хананд металл фасадын ажил хийх байтал шавардаж, эмулсьдсэн.
- Уулбаян сумын соёлын төвийн барилгын хувьд гадна талбайн 150м² бетон хучилт болон ногоон байгууламжийн зүлэгжүүлэлтийн ажлыг хийгээгүй, дээврээс ус гоожсон, цонх сийгүүртэй дулаан алдагдал ихтэй. Дээрх зөрчлийг арилгуулахаар ГХБХБГ-аас 2022 оны 09 сарын 12 өдөр албан бичгээр хугацаатай албан шаардлага хүргүүлсэн боловч гүйцэтгэгч компани биелүүлээгүй байна.
- Онгон сум сургуулийн барилга буулгаж, 160 суудалтай 2 дугаар байр барих төсөл арга хэмжээний барилгын сантехникийн шугам хоолойг ил явуулж, модон хаалт хийсэн, зургийн дагуу хийж гүйцэтгээгүй, хана цуурсан, бохирын худаг бөглөрсөн, дээврээс ус гоожсон.
- Наран сумын 150 ортой цэцэрлэгийн барилгын гадна суурилуулсан хүүхдийн тоглоом зураг төсөвт зааснаас хямд үнэтэй, сүүдэр талын цонхнууд өвөл цантсан, явган замын хавтангууд хагарсан.
- Мөнххаан сумын 17 ортой эрүүл мэндийн төвийн барилгын хувьд холбоо дохиолол холбогдсон боловч ажилладаггүй, ар талын өрөөнүүдийн /нар тусдаггүй/ дотор температур өвлийн улиралд 9 градусаас дээш халдаггүй. Халаалтын түрэлтийн насос, гүнийн худгийн ус татах насосууд эвдэрснээс Эрүүл мэндийн төв 0,9 сая төгрөгөөр насос худалдан авсан, нийт 7 камер суулгахаас 4 камер дутуу суулгасан.
- Баруун-Урт сумын 2 дугаар сургуулийн урлаг заалны өргөтгөлийн барилгыг улсын комисс 2022.11.30-нд хүлээн авсан бөгөөд дулаан алдагдал ихтэй, өвлийн цагт үйл ажиллагаа явуулах боломжгүй байдаг байна. Дулаан алдагдлын шалтгааныг аудитын явцад шалгаж үзэхэд тус барилгын дээврийн сэндвичин хавтан болон хана хоёрын завсар хоорондын чигжээс, дулаалгыг

дутуу хийсний улмаас нарны тусгал зай завсраар нь гэрэлтэж байгаа бөгөөд энэ нь дулаан алдагдлын үндсэн шалтгаан болж байна.

2.1.6. Наран сумын сургуулийн 50 ортой дотуур байрны барилгыг аймгийн Засаг даргын 2021 оны 10 сарын 8-ны өдрийн захирамжаар 20 хүний бүрэлдэхүүнтэй улсын комисс байгуулсан. Улсын комисс тус барилгад 65 ажил хийж гүйцэтгээгүй байгааг дуусгах үүрэг даалгавар гүйцэтгэгч компанид өгсөн боловч хийгээгүй байна. Тухайлбал: Үерийн ус зайлуулах бетон суваг хийх, үүдний саравч дээр ус зайлуулах налуу хийж хар цаас наах, гадна кабель солих, хоол үйлдвэрлэлийн өрөөний гүйцэтгэл дутууг гүйцээх зэрэг ажлууд байна. Мөн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас 2021 оны 11 сард комиссын гишүүдээс өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг шалгаж үзэхэд биелэлт хангалтгүй байгааг ХБТХОХ-т 2021 оны 11 сарын 30-ны 1/396 тоот албан бичгээр хүргүүлсэн байна. Иймд барьцаа хөрөнгийн дансанд байгаа 41.0 сая төгрөгийг комиссоос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлсний дараа олгож, барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах комисс дахин ажиллуулах шаардлагатай байна.

2.1.7. Дээрх барилгын ажлууд дутуу болон чанаргүй хийгдсэн зөрчлийг арилгуулах хугацаатай албан шаардлагыг, мөн буруутай албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах албан шаардлагыг тус тус хүргүүлээ.

2.1.8. Гүйцэтгэгчээс шалтгаалж барилгын ажил гүйцэтгүүлэх гэрээг цуцлах нөхцөл байдал үүссэн 2 төсөл арга хэмжээ байна. Үүнд:

2.1.9. Баяндэлгэр сумын 300 суудалтай соёлын төвийн барилгын үндсэн суурь 1 дүгээр давхрын төмөр бетон каркас угсралтын ажил, тогооны барилга, гадна дулаан, бохир усны шугамын газар шорооны ажлууд хийгдсэн, гадна холбооны лотки угсрагдсан боловч гүйцэтгэгчээс шалтгаалж гэрээ цуцлах шаардлага үүссэн. Тус компанитай байгуулсан гэрээний 5-р зүйл, гэрээний ерөнхий нөхцөлийн 56-р зүйлд заасны дагуу гэрээг цуцлах нөхцөл үүссэн байна.



2.1.10. Дарьганга зусланг орчин үеийн стандартад нийцсэн амралт, аялал жуулчлалын цогцолбор болгон шинэчлэх төсөл арга хэмжээний барилгын ажлын явц 38.6 хувьтай, барилгын ажил чанаргүй, чулуун хөвөнгөөр дулаалга хийх байтал хөөсөнцөр хийсэн, мөн 3 давхар шилтэй вакум цонх хийх байтал 2 давхар шилтэй цонх хийсэн. Гүйцэтгэгч гэрээнд заасан хугацааг баримтлаагүй, чанаргүй гүйцэтгэл гаргаж, цаашид гүйцэтгэх боломжгүй гэж үзэн гэрээ цуцлах шаардлага үүссэн.



2.1.11. Орон нутагт эрх шилжиж ирээгүй Боловсрол, шинжлэх ухааны яамны захиалгаар 2018-2020 онуудад Эрдэнэцагаан суманд 200 ортой хүүхдийн цэцэрлэг, гүйцэтгэгч “Хар үжин” ХХК, Баяндэлгэр суманд 200 ортой хүүхдийн цэцэрлэг, гүйцэтгэгч “Оточ ноёдууд” ХХК байна. Эдгээр төсөл арга хэмжээ нь гүйцэтгэгчээс шалтгаалж 2022 оноос хойш барилгын ажил зогссон, төсвийн хөрөнгө оруулалт үр ашиггүй болж байгаа тул /2023 онд хийсэн Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланд дурдсан/ гэрээнд заасан хариуцлагыг тооцож, цуцлах шаардлага үүссэн байна. Дээрх компаниудад гэрээний хариуцлага тооцох, гэрээ цуцлуулах талаар Аймгийн Засаг даргаас Боловсролын ерөнхий газрын даргад 2022 оны 9 сарын 16-ны өдөр хүргүүлсэн боловч тодорхой шийдвэр ирүүлээгүй байна. Иймд гүйцэтгэгч компаниудтай байгуулсан гэрээг цуцлах саналыг яаманд уламжлах талаар Үндэсний аудитын газарт санал хүргүүллээ.

Б.2. Төсөл арга хэмжээний хэрэгжилттэй холбоотой зөрчил давтагдаж байгаа нь бүх шатны хяналт үр нөлөөгүй байгааг илтгэж байна.

2.2.1. Захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлж буй байгууллага болон төрийн захиргааны албан хаагч нар техникийн хяналт болон төсөв санхүүгийн хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна. Тодруулбал:

- Барилгын ажлын гүйцэтгэлийг баталгаажуулахдаа 4 төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг бодит гүйцэтгэлээс илүү дүнгээр баталгаажуулж, 601.2 сая төгрөгийн санхүүжилт илүү олгосон. Тухайлбал Соёл амралтын хүрээлэн төсөл арга хэмжээний 9.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын санхүүжилтийг бодит гүйцэтгэлээс 288.3 сая төгрөгөөр илүү олгосон.
- Барилгын ажил чанаргүй, зураг төслөөс зөрүүтэй гүйцэтгэсэн байхад зөрчлийг арилгуулаагүй, арилгуулах талаар хангалттай арга хэмжээ авч ажиллаагүй байна. Тухайлбал Баруун-Урт сумын 2 дугаар сургуулийн урлаг заалны дээвэр, хана хооронд зай завсартай, нарны гэрэл тусаж байхад захиалагчийн техник хяналт хэрэгжүүлсэн байгууллагууд барилгын норм,

дүрмийн дагуу баригдсан гэж дүгнэлт гаргаж, улсын комисс хүлээн авсан, тус барилгын дулаан алдагдлын шалтгааныг аудитаар илрүүлсэн.

- Барилгын ажил дуусаж, ашиглалтад хүлээн авсан боловч комисс нь өөрсдийн өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг эргэн шалгаагүй, биелэлтийг хангуулахын тулд үр нөлөөтэй ажиллаагүй. Тухайлбал Уулбаян сумын соёлын төвийн барилга, Наран сумын дотуур байрны барилгуудын хувьд 2021 оны 10-11 сард улсын комисс акт үйлдэж ашиглалтад хүлээн авсан боловч комиссоос өгсөн үүрэг даалгавар одоог хүртэл биелээгүй байна. Мөн Уулбаян сумын соёлын төвийн барилгын гүйцэтгэгч комиссоос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй байхад чанарын баталгаат хугацааны барьцааг чөлөөлсөн.

2.2.2. Барилгын ажлын гүйцэтгэлийг бодитоор хянах, санхүүжилт илүү олгохгүй байх, ажлын чанарт тавих хяналтыг сайжруулах, захиалагчийн техник хяналт хэрэгжүүлэгч байгууллагууд хүний нөөц, орон тоог нэмэгдүүлэх, улсын комиссын үүрэг даалгавар бүрэн биелээгүй тохиолдолд комиссын акт үйлдэж байгаа нь барилга, байгууламж ашиглалтад оруулах дүрэмд нийцэхгүй байна. Комиссын үүрэг даалгавар биелээгүй тохиолдолд гүйцэтгэлийн баталгаа болон чанарын баталгаат хугацааны барьцааг чөлөөлөхгүй байж, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг дээшлүүлэх, буруутай албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах албан шаардлагыг хүргүүлээ.

2.2.3. Барилгын ажлын явцад техникийн хяналт хэрэгжүүлэхдээ цөөн тооны хүний нөөцөөр богино хугацаанд олон барилгын ажлыг хянаж байгаа нь хяналтыг үр нөлөөгүй болоход голлон нөлөөлсөн байна.

2.2.4. Захиалагчийн техник хяналт болон зохиогчийн хяналтыг сайжруулах, чанартай хяналт тавиулахын тулд холбогдох дүрэм, журмын зарим зохицуулалтыг тодорхой болгох нь зүйтэй байна. Тодруулбал Барилгын захиалагчийн техникийн хяналт болон зохиогчийн хяналт хэрэгжүүлэх субъектүүд **барилгын ажлын бүх үе шатанд барилгын норм, дүрмийн хэрэгжилтийг хянаж, шалгахад зарцуулбал зохих хугацааны доод хэмжээг** барилгын төсөвт өртгийн хэмжээтэй уялдуулан хүн/өдрөөр тооцон нормчилж, холбогдох заалт, зохицуулалтыг “Барилгын ажлын захиалагчийн дүрэм” болон “Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм”-д тодорхой тусгах нь зүйтэй байна. Ингэснээр барилгын дээвэр, таазнаас бороо, цасны ус гоожих, цонх сийгэх, цантах, дулаан алдагдал, хана цуурах гэх мэт зөрчлүүд жил бүр давтан гарах нь багасаж, барилгын чанар дээшилж, төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөж нэмэгдэх юм.

Б.3. Хэрэгжүүлж дууссан төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаагүй байна.

2.3.1. Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолоор Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийсэн үл хөдлөх хөрөнгийг захиалагчийн саналыг үндэслэн эзэмшигч, ашиглагч байгууллагыг тогтоон данс бүртгэлд бүртгэхийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт даалгасан. Үүний дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийсэн үл хөдлөх хөрөнгийг захиалагчийн саналыг үндэслэн Орон нутгийн өмчид өгөх асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хурлаар хэлэлцэн, тогтоолоор албажуулж орон нутагт ирсний дараа АИТХ-аар хэлэлцэн холбогдох газарт бүртгэх шийдвэр гаргаж бүртгүүлдэг.

Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

Хүснэгт 1. Улсын төсвийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг данс бүртгэл (сая төгрөг)

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Бүртгэсэн дүн
1	Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Сүхбаатар, Мөнххаан сум/	1,950.5	1,250.5	
2	Сургуулийн дотуур байрны барилга, 50 ор, Наран сум	870.7	7.4	590.3
3	Сургуулийн барилга 160 суудал, Онгон сум	1,915.9	215.0	1,638.0
4	Сургуулийн урлаг заалны өргөтгөлийн барилга /Сүхбаатар, Баруун-Урт сум, 2 дугаар сургууль/	746.4	126.1	620.2
5	Цэцэрлэгийн барилга, 100 ор, Наран сум	1,898.9	1,738.9	
6	Соёлын төвийн барилга, 240 суудал, Уулбаян сум	1,574.6	74.6	
7	Авто замын уулзварын гэрлэн дохио, Баруун-Урт сум	821.9	23.1	799.9
8	Мал эмнэлгийн хяналт, ариутгалын пункт, Сүхбаатар	1,147.7	147.7	

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газар, ОНӨГ

2.3.2. УИХ-ын 2021 оны “Монгол улсын 2022 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 88 тоот тогтоолоор үнийн өсөлтийн индексийг тооцож, материалын үнийн нэмэгдлийг Төсвийн тухай хуульд баталсан бөгөөд дээрх үнийн нэмэгдлийг капиталжуулж бүртгээгүй 4 төсөл арга хэмжээний 371.6 сая төгрөг байна. Тухайлбал Наран сумын 50 ортой дотуур байрны төсөвт өртөг 870.7 сая төгрөгөөр бүртгэлд тусгахаар байхад 590.3 сая төгрөгөөр данс бүртгэлд тусгасан байна.

2.3.3. Төсвийн тухай хуульд 2022-2023 онд хэрэгжүүлэх "Шинэ хөдөө" төслийн төсөвт өртгийн 833.5 сая төгрөгөөр хэрэгжүүлэх 2 багцад, мөн 2023 онд 500.0 сая төгрөгийн 4 багцад хувааж хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд:

Хүснэгт 2. Шинэ хөдөө төслийн 6 багцын нэр, төсөвт өртөг (сая төгрөг)

№	Төсөл арга хэмжээний багц	Мөнгөн дүн
1	Хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж авахад	653.5
2	Малын үүлдэр угсааг сайжруулах өсвөр насны үржлийн бух нийлүүлэхэд	180.0
3	Багийн дарга, хөдөө аж ахуйн, мал эмнэлэг, үржлийн тасгийн мэргэжилтнүүдийг зөөврийн компьютероор хангахад	286.0
4	Хүнсний ногоо тариалах, мод үржүүлэх зорилгоор хүлэмж авахад	84.0
5	Өвс хаман боогч	112.0
6	Арьс, шир боловсруулах тоног төхөөрөмж	18.0
Нийт дүн		1,333.5

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газар

2.3.4. Эдгээр ТАХ-ээс арьс, шир боловсруулах 18.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авах тендерийг зарласан боловч сонгон шалгаруулалтад иргэн, аж ахуйн нэгж оролцоогүй байна.

2.3.5. Хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж нийлүүлэх тендерт Техник хаус ХХК шалгарч гэрээний дагуу 1 ширхэг белорус 82.1 трактор 86.8 сая, 9 ширхэг тукон 1600 маркийн өвс хаман боогчийг 567.0 сая нийт 653.5 сая төгрөгөөр нийлүүлж, аймгийн ЗДТГ-ын дансанд бүртгэсэн.

2.3.6. Малын үүлдэр угсааг сайжруулах үржлийн бух нийлүүлэхэд Нэмэр их ХХК-тай байгуулсан гэрээгээр хар ангус, симменталь, швейцарын бор үүлдрийн 12-24 сартай үржлийн 32 бухыг 2022 онд 80.0 сая төгрөгөөр, 40 бухыг 2023 онд 100.0 сая төгрөгөөр худалдан авахаар гэрээ байгуулсан бөгөөд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж 2023 онд нийлүүлэх 40 бухыг 25 болгон бууруулж, нийт 2022-2023 онд 57 бух нийлүүлэгдсэн байна. Данс бүртгэлд тусгасан байдлыг авч үзэхэд 2022 онд нийлүүлэгдсэн 32 бухыг данс бүртгэлд тусгаж, 2023 онд нийлүүлэгдсэн 25 толгой бухыг данс бүртгэлд тусгаагүй байна.

2.3.7. Багийн дарга болон хөдөө аж ахуйн мэргэжилтнүүдийн зөөврийн компьютероор хангах барааны нийлүүлэгчээр Ухаалаг оффис ХХК шалгарч Lenovo маркийн notebook 130 ширхгийг нэг бүрийн үнэ 2.19 сая төгрөг, нийт 285.4 сая төгрөгөөр нийлүүлсэн. Аймгийн Засаг даргын 2023 оны А/488 дугаар “Хөрөнгө бүртгэж, эзэмшүүлэх тухай” захирамжаар 130 ширхэг notebook-ийг олгох хуваарь батлагдаж, 13 ширхэг notebook-ийг хуваарьт заасан байгууллагууд данс бүртгэлд тусгаагүй тул Орон нутгийн өмчийн газарт тус байгууллагуудын данс бүртгэлд тусгуулах зөвлөмж болгосон.

2.3.8. Алтын сапа ХХК-тай байгуулсан “Нийлэг хальсан хүлэмж” бараа нийлүүлэх гэрээгээр 4*8 метрийн хэмжээтэй 20 ширхэг хүлэмжийг 43.1 сая, 6*10 хэмжээтэй 10 ширхэг хүлэмжийг 32.6 сая нийт 75.7 сая төгрөгөөр 30 ш хүлэмж хүлээн авч аймгийн ЗДТГ-ын данс бүртгэлд 68.8 сая төгрөгөөр бүртгэж, тээврийн хөлс 6.3 сая төгрөгийг НББ-ийн стандартын дагуу нэмж бүртгээгүйг аудитын хугацаанд залруулсан.

2.3.9. Агротрак ХХК-тай “Дөрвөлжин хаман боогч” бараа нийлүүлэх гэрээг байгуулан Тукан НР маркийн 2 ширхэг өвс хаман боогч 111.9 сая төгрөгөөр худалдан авсан. Аймгийн Засаг даргын 2023.08.17-ны өдрийн “Хөрөнгө бүртгэж, эзэмшүүлэх тухай” А/514 дугаар захирамжаар АЗДТГ-ын данс бүртгэлд бүртгэхээр тусгасан боловч бүртгэгдээгүй байна.

БҮЛЭГ В. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР БИЙ БОЛСОН ХӨРӨНГИЙН ТҮРЭЭСИЙН ОРЛОГЫН ТӨВЛӨРҮҮЛЭЛТИЙГ ЭС ТООЦВОЛ БАРИЛГЫН БАЙГУУЛАМЖИЙН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНҮҮД ТӨЛӨВЛӨСӨН ҮР ДҮНД ХҮРСЭН БАЙНА.

В.1. Шинэ хөдөө төслийн хүрээнд бий болсон техник хэрэгслийн түрээсийн орлого бүрэн төвлөрөөгүй байна.

3.1.1. Наран сумын цэцэрлэг, дотуур байр, Онгон сумын бага сургууль, Мөнххаан сумын ЭМТ, иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга, Уулбаян сумын соёлын төв, авто замын уулзварын гэрлэн дохио, 3.03 хатуу хучилттай авто зам, 2-р сургуулийн урлаг заалны барилгуудыг зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар нь ашиглаж байгаа бол мал эмнэлгийн ариутгалын пунктын барилгыг малын гоц халдварт өвчин гараагүй учраас ашиглаагүй, ашиглах шаардлага үүсээгүй байна.

3.1.2. Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төслийн хүрээнд авсан хүлэмжийг 4 жилийн хугацаатай хүнсний ногоо тариалдаг 28 иргэнд түрээсэлсэн. 2023 онд 19 хүлэмжийг 9.3 сая төгрөгөөр, 8 хүлэмжийг 5.9 сая төгрөгөөр түрээслүүлж 15.2 сая төгрөг төвлөрүүлэхээс 11.3 сая төгрөг төвлөрүүлж 3.9 сая төгрөгийн түрээсийн орлого дутуу төвлөрсөн тул албан шаардлага хүргүүллээ.

3.1.3. Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төслийн хүрээнд 2022 онд ирсэн өвс хаман боогчийг 9 иргэнд нийт 20250 боодол өвс, 2023 онд ирсэн өвс хаман боогчийг 2 иргэнд нийт 4000 боодол өвс хүлээн авах нөхцөлтэй 3 жилийн хугацаатай түрээслүүлсэн байна. Түрээсийн гэрээний дагуу 2022, 2023 онуудад нийт 40500, 2 хаман боогчийн түрээсийн төлбөрт 2023 онд 4000 нийт 44500 боодол өвс хүлээн авах байснаас 21408 хүлээн авч 23092 боодол өвс дутуу авсан байна. Гэрээнд заасны дагуу түрээсийн төлбөрийг бүрэн авах талаар албан шаардлага хүргүүллээ.

3.1.4. "Шинэ хөдөө" төслийн хүрээнд нийлүүлэгдсэн өвс хаман боогч болон хүлэмжийг АИТХ-ын шийдвэр гараагүй байхад иргэнд түрээслүүлэх гэрээний 4 дүгээр зүйлд түрээслүүлж буй хөрөнгийг түрээсийн төлбөрийг барагдуулсан үед түрээслэгч талд хөрөнгө болгон өгөхөөр тусгасан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 3-т "Орон нутгийн өмчид хамаарах үндсэн хөрөнгийг бусдын өмчлөлд шилжүүлэх, барьцаалах, шинээр олж авах асуудлыг гагцхүү иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний хуралдааны чөлөөт цагт Хурлын дарга шийдвэрлэнэ." гэж заасантай нийцээгүй байна.

В.2. Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь хэрэгцээ шаардлагыг хангаж, төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна.

3.2.1. Наран сумын сургуулийн өмнөх боловсролд 2023 оны байдлаар 145 хүүхэд хамрагдахаас 119 хүүхэд хамрагддаг. Цэцэрлэгийн хуучин барилга нь 75 хүүхдийн багтаамжтай бөгөөд анги танхим хүрэлцдэггүй. Сумын сургуулийн дотуур байрын хуучин барилга 1981 онд ашиглалтад орсон, мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр хүн амьдрах боломжгүй болсон тул АИТХ-аас актлах шийдвэр гарч тус барилгыг данснаас хассан.

3.2.2. Онгон сумын сургуулийн барилга 440 хүүхдийн багтаамжтай, одоогоор 721 хүүхэд суралцдаг. Уулбаян сумын соёлын төвийн барилга 1964 онд ашиглалтад орсон, үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон.

3.2.3. Мөнххаан сумын ЭМТ-ийн барилга 1997 онд ашиглалтад орсон бөгөөд угаалгын болон ариутгалын өрөөгүй 2013 оны сум тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн бүтэц үйл ажиллагаа MNS 5081 стандартад нийцээгүй.

3.2.4. Аймгийн төвийн 7 уулзвар хатуу хучилттай замаар холбогдсон, авто оношилгооны төвөөр 2021 онд 9751, 2022 онд 10530, 2023 онд 13881 авто машин үзлэгт орж хөдөлгөөний эрчим нэмэгдсэн тул гэрлэн дохиог дээрх 7 байршилд байршуулах зайлшгүй шаардлага үүссэн. Баруун-Урт сумын 2-р сургуулийн барилга 2005 онд ашиглалтад орсон боловч урлаг заалны барилгагүй баригдсан байна.

3.2.5. Дээрх ТАХ-нүүдийг хэрэгжүүлснээр зайлшгүй шаардлагатай хэрэгцээг хангаж байгаа боловч зарим барилгын хувьд ашиглалтын шаардлага хангаагүй, ашиглалтын явцад технологийн алдаа гарсан нь хүүхдийн сурах, иргэдийн

эмчлүүлэх, ажилчдын ажиллах хэвийн нөхцөлд сэргөөр нөлөөлж байна. Тухайлбал: Наран сумын дотуур байр, Онгон сумын бага сургуулийн урлаг, спортын заал, Мөнххаан сумын ЭМТ, 2-р сургуулийн урлаг заалны барилга дулаан алдагдалтай, цонхноос сийгдэг, өрөөний температур өвлийн улиралд 6-9 градустай ердийн температурт хүрдэггүй, дээврээс дусаал гоождог зэрэг нь хөдөлмөрийн хэвийн нөхцөлийг хангахгүй, эрүүл мэндэд сэргөөр нөлөөлж байна.

3.2.6. Харин баруун-Урт сумын 3.03 км хатуу хучилттай авто замын хувьд аймгийн төвийг 5 тойргоор хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөнд тусгагдаж хэрэгжүүлэх ТАХ-ний жагсаалтад эрэмбэлж батлуулсан, малын гоц халдварт өвчин гарсан тохиолдолд ашиглах ариутгалын пункт аймгийн хэмжээнд байхгүй тул мал эмнэлгийн хяналт, ариутгалын пунктыг төлөвлөж батлуулсан байна.

---oOo---

Холбогдох байгууллагын санал:



МОНГОЛ УЛС
СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас, факс: 70512121, 70518232

2024.04.25 № 01/524
танай _____-ны № _____-т

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Тайлбар хүргүүлэх тухай

2023 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцаад тайланд тусгагдсан зарим дүгнэлтүүдийг хэрэгжүүлэх арга хэмжээг авах, мөн санал нийлэхгүй байгаа зарим дүгнэлтүүдэд холбогдох тайлбарыг хийн хүргүүлж байна. Үүнд:

1.1.3-т: Нормчлолын сангийн хөрөнгийг холбогдох дансанд захиалагч төвлөрүүлээгүй байна гэсэн байна.

Автозамын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т Автозамын норм, норматив, техникийн баримт бичгийг боловсруулах, батлах, боловсронгуй болгож хөгжүүлэх "Автозамын норм, норматив сан"-тай байна. Уг сангийн журмыг Зам тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 142 дугаар тушаалаар баталсан. Уг журмын 3 дугаар зүйлийн 3.2-т "Хуулийн этгээд, иргэн нь тухайн жилд гүйцэтгэх улс болон нийслэл, орон нутаг, тусгай зориулалтын автозам, замын байгууламжийн барилга, их засвар, техник эдийн засгийн үндэслэл, зураг төслийн ажлын төсөвт өртгөөс 0,4 хувиар тооцож, санхүүжилтийн эрх нээгдсэнээс хойш ажлын 14 хоногт багтаан Автозамын норм, норматив санд төвлөрүүлнэ. Мөн Барилга хот байгуулалтын сайдын 2019 оны 04 дүгээр тушаалаар "Барилга байгууламжийн норм, нормативын журам"-ыг шинэчлэн баталсан. Үүний 3.2-т Аж ахуй нэгж, байгууллага нь санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг оны эхний өссөн байдлаар дараах байдлаар тооцож улирал бүрийн дараа сарын 5-ны дотор сангийн дансанд төвлөрүүлнэ. 3.2.1, 3.2.2, 3.2.3-т тусгагдсан дүнгийн 0,18 хувиар тус тус тооцно гэж заасан байдаг.

Иймээс дээрх журмуудын дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч нар нь ажлын гүйцэтгэлээс тухай бүр норм нормативын сангийн зардлыг тус бүрийн дансанд төвлөрүүлэх үүрэгтэй болно.

1.1.4-т: "Барилгын төсөв зохиох дүрэм"-ийн 5.10-д Тоног төхөөрөмжийн зардалд тусгайлан бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зориулагдсан, барилгын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай тоног төхөөрөмжийг төлөвлөж өгдөг. Барилгын хөгжлийн төвөөс тус тоног төхөөрөмж шаардлагатай эсэхийг хянаж шийдвэрлэдэг. Гүйцэтгэгч компанитай гэрээ байгуулах шатанд тус ажлыг хянаж зөвшилцөх талаар харилцан тохиролцдог болно.

1.1.6-т: Барилга, байгууламжийн архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулахдаа тайланд тусгагдсан дараах шаардлагыг анхаарч аймгийн ерөнхий архитектурт албан бичгээр хүргүүлж ажиллана.

2204050223

1.2.1-т: Мөнххаан сумын иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилгын гадна ажлыг зураг төсөвт төлөвлөөгүй орхисноор ОНХС-ийн 321,0 сая төгрөгийн хөрөнгөөр санхүүжүүлж гүйцэтгэсэн гэсэн байна. Уг барилгын зураг төсөв нь БХТ-ийн 2021 оны 1321/2021 тоот магадлалын дүгнэлттэй, 2471,7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй батлагдсан зураг төсөвтэй ТАХ, гэвч 2022 онд УТ-ийн хуульд батлахдаа 2003,6 сая төгрөгөөр батлагдсан. Иймд бид ХАА-г зарлахдаа батлагдсан төсөвт багтаан гадна тохижилтын ажлын тоо хэмжээг хасаж тендер зарлаж, гүйцэтгэгч тодорсон.

А.3-т: Зарим төсөл арга хэмжээний бодит гүйцэтгэлийг 601,2 сая төгрөгөөр илүү дүнгээр баталгаажуулж, санхүүжилт олгосон байна.

1.3.2-т: Дарьганга сумын 150 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилгын магадлалаар батлагдсан төсөвт өртөг 3271,6 сая төгрөг /БХТ-ийн 2021 оны 07 сарын 06-н өдрийн 927/2021 тоот дүгнэлттэй/. Анх 2021 оны улсын төсөвт батлагдсан зураг төсөвгүй ТАХ-д 1,6 тэрбум төгрөг батлагдсан. 2024 оны хуулиар магадлалын зөрүү дүн төсөвт батлагдсан. Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулахад 3,2 тэрбум төгрөгийн ажлаас гадна инженерийн шугам сүлжээ /дулаан, цэвэр усан хангамж, бохир усан хангамж, цооног, гадна цахилгаан, гадна цахилгааны тоног төхөөрөмж, холбоо/, гадна зам талбай, тохижилт, дотор халаалт, агаар сэлгэлт, цэвэр бохир усан хангамжийн ажлыг хасч ХАА зарлагдсан бөгөөд батлагдсан төсөвт багтаан БШУЯ/202102058 тоот 1599,9 сая төгрөгийн гэрээг байгуулсан. Иймд барилга угсралтын явцад гүйцэтгэгч компани өөрийн үндсэн гэрээт ажилд тусгагдаагүй ч тухайн барилга угсралтын явцад үе шат бүрээр далдлагдах дотор халаалт, шал, бохир ус, гадна цахилгааны 0,4 кВА кабель шугамын 103,9 сая төгрөгийн нэмэлт ажлыг зайлшгүй хийж гүйцэтгэсэн байна. Мөн 2024 оны төсөвт уг барилгын гадна инженерийн шугам сүлжээний дутуу ажлуудын санхүүжилт батлагдсан бөгөөд Засгийн газрын 2023 оны 489 дүгээр тогтоолоор нэмэлт гэрээг байгуулах чиглэл ирж "Монмарс холдинг" ХХК-тай 1,671,7 сая төгрөгийн нэмэлт гэрээг 2023 оны 12 сарын 28-ны өдөр байгуулсан.

1.3.3-т: Спорт цогцолборын барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн явцад гүйцэтгэгч компани зураг төсөвт тусгагдаагүй 150 сая төгрөгийн ажлыг нэмэлтээр хийсэн байна. Үүнд спорт заалны тоглолтын талбайн шал нь зураг төсөвтөө захиалсан банз байсныг олон улсын стандартын шал болох агч модон шал, 1-р давхрын тааз нь замаск эмульс байсныг дүүжин тааз болгон сайжруулсан.

Мөн Соёл амралтын хүрээлэнгийн Багц 2 гэрээт ажил гэрээний үнийн дүн 5513,2 сая төгрөг 2023 онд санхүүжих дүн 1000,0 сая төгрөг батлагдсан. Гэвч бодит байдал дээр багц 1, багц 2 гэрээт ажлууд нь хоорондоо уялдаа холбоотой хийгдэх бөгөөд мини тоглоомын парк, алсыг харагч гэх мэт тоглоомууд угсрагдаж суурилуулагдсанаар явган зам талбайн тохижилтын ажил хийгдэнэ. Иймд гүйцэтгэгч компани багц 2- гэрээт ажил дээр 1536,0 сая төгрөгийн ажлыг урьдчилж хийсэн бөгөөд төсвийн жилд санхүүжих мөнгөн дүнд зохицуулалт хийлгэх хүсэлтийг БХБЯ-д хүргүүлсэн ч уг асуудал шийдвэрлэгдээгүй. Соёл амралтын хүрээлэнгийн багц1, багц2 ажлыг гүйцэтгэж буй компаниуд нь хоорондоо хамаарал бүхий, төлөөлөн удирдах зөвлөл, хувьцаа эзэмшигч нь 1 хүн байдаг.

Дээрх ажлын материалууд барилгын талбайд захиалагдаж буугдсан байсан ба түлш шатахууны хомсдол, 10 сарын сүүлээр их хэмжээний цас орж бүтээн байгуулалтын ажлууд харьцангуй эрт зогссон зэрэг шалтгаалсан.

Сүхбаатар аймагт хэрэгжиж буй Улсын төсвийн хөрөнгө оруулалтын ажилд захиалагчийг төлөөлж хяналтыг аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын

газар, Барилгын хөгжлийн төв гэрээний үндсэн дээр хэрэгжүүлэн ажилладаг. Гэвч өмнө хэрэгжүүлсэн төсвийн хөрөнгө оруулалтын ажлууд чанаргүй болсон асуудлууд гүйцэтгэлийн явцад нэлээд гарч байна. Захиалагчийн зүгээс захиалагчийн хяналтыг 2 үе шаттайгаар хэрэгжүүлж, захиалагчийн хяналтын инженерүүд болох аймгийн ГХБХБГ-ын холбогдох албан тушаалтнууд, БХТ-ийн холбогдох албан тушаалтнууд гүйцэтгэлийг баталгаажуулж зурсан тул захиалагчийн хувьд гүйцэтгэлийг баталгаажуулдаг.

Мөн барилгын хөгжлийн төвд одоогоор манай аймгийг хариуцсан хяналтын инженер томилогдоогүй байгаа нь барилга угсралтын ажлын үе шат бүрт хяналт хэрэгжүүлэхэд хүндрэл үүсэж, хяналт суларч, БУА чанаргүй, зураг төслөөс зөрсөн асуудлууд гарч байна. Мөн орон нутаг дахь мэргэжлийн инженерийн боловсон хүчний хангамж дутмаг, БХТ-ийн хяналтын инженерт ногдох объектын тоо олон зэргээс захиалагчийн хяналт үе шат бүрээрээ хэрэгжихгүй байна.

Иймд захиалагчийн зүгээс 2024 онд шинээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажлын захиалагчийн хяналт хэрэгжүүлэх гэрээг Барилгын хөгжлийн төв болон газрын харилцаа барилга хот байгуулалтын газартай байгуулаагүй байна. Учир нь Барилгын хөгжлийн төвтэй байгуулсан өмнөх онд хэрэгжүүлсэн гэрээг дүгнэх, аймаг хариуцсан хяналтын инженер болон бусад мэргэжлийн инженерийг томилон ажиллуулах, явцын хяналт чанаргүй байвал хариуцлагын асуудлыг гэрээнд тусгах талаарх албан бичгийг БХТ-д хүргүүлэхээр бэлтгэж байна.

Захиалагчийн хяналт хэрэгжүүлэх асуудлаар аймгийн Газрын харилцаа хот байгуулалтын газрын холбогдох албан хаагчидтай захиалагч тал уулзсан бөгөөд гэрээгээр инженер техникийн хүмүүсийг авч ажиллуулахаар чиглэл өгч ажилласан.

2.1.4. Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар барилгын хяналтын улсын байцаагчийн сул орон тоог нөхөх захиалгаа өгч ажлын байрны тусгай шалгалт зарлагдсанаар нөхөгдсөн. Мөн 2024 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын ажлуудад гэрээгээр инженер техникийн ажилтан авч ажиллуулах талаар сишлэл өгч харилцан тохиролцсон болно.

2.3.1-т: Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1-д Төрийн өмчийн бүртгэл, хяналт шалгалтыг сайжруулахтай холбогдуулан дор дурдсан арга хэмжээг төсвийн ерөнхийлөн захирагч, ерөнхий менежерийн саналыг үндэслэн хэрэгжүүлж байхыг Төрийн өмчийн хороо (Д.СУГАР)-нд даалгасугай:

а. улсын төсвийн санхүүжилтээр бий болгосон болон гадаадын хандивлагч байгууллага, иргэд, хуулийн этгээдээс Монгол Улсын Засгийн газарт зориулж хэрэгжүүлсэн төсөл, зээл, тусламж, хандиваар бий болсон хөрөнгийг тоолж үнэлсний үндсэн дээр эзэмших этгээдийг тогтоож, бүртгэлд тусгаж байх;

б. улсын төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутагт бий болсон хөрөнгийн үнэ, өртөг, тоо хэмжээ, эзэмших орон нутгийн өмчит хуулийн этгээдийг тогтоож, бүртгэлд тусгаж байх;

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.5-д ... "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам"-ын дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьсан барилга, байгууламжийг барьж дуусгах хүртэл захиалагч байгууллага нь "Бусад эргэлтийн хөрөнгө" дансанд бүртгэн санхүүгийн тайландаа тусгана.

Улсын комисс барилга, байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авсан актыг үндэслэн захиалагч байгууллага болон төсвийн ерөнхийлөн захирагчаас тухайн үл хөдлөх хөрөнгийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд эзэмшүүлэх саналыг

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж шийдвэрлэснээр эзэмшигч байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэнэ гэж заасан.

Тус үл хөдлөх хөрөнгийн захиалагч болон Төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа яамдууд тул тухайн хөрөнгө эхлэхээс авхуулаад дуусах хүртэлх бүх бүртгэл тухайн яамны данс бүртгэлд дээрх 2 эрх зүйн актуудын хүрээнд мөрдөгдөж явж байгаа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтад хийсэн аудитын тайланд захиалагч болон төсвийн ерөнхийлөн захирагч буюу яамд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэр гараагүй хөрөнгүүдийг аймгийн ерөнхийлөн захирагчийн зөрчил болгож зөвлөмж өгч байгаа нь хууль, дүрэмд нийцэхгүй байна гэж үзэж байна. Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад орсон барилга байгууламжийн өмчлөлийн асуудлыг шийдвэрлэх, балансад бүртгэх процесс цаг хугацаа их орж, төсвийн жил дамжин хэрэгжих асуудлууд гарч байгаа нь алдаа зөрчлийн тоог нэмэгдүүлж байгаа тул уг журмыг сайжруулах хэрэгцээ шаардлага байна.

2.3.6-г: “Шинэ хөдөө” төслийн хүрээнд 2023 онд нийлүүлэгдсэн 25 бух буюу 62,5 сая төгрөгийн хөрөнгийг аймгийн Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн А/532 дугаар “Хөрөнгө бүртгэж, эзэмшүүлэх тухай” захирамжаар аймгийн Засаг даргын Тамгын газрын данс бүртгэлд 2024 оны 2 дугаар улиралд тусгахаар ажиллаж байна.

2.3.9-г: “Шинэ хөдөө” төслийн хүрээнд 111,9 сая төгрөгөөр нийлүүлэгдсэн 2 ширхэг дөрвөлжин хаман боогчийг аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн А/514 дугаар “Хөрөнгө бүртгэж, эзэмшүүлэх” тухай захирамжаар аймгийн Засаг даргын Тамгын газрын данс бүртгэлд 2024 оны 2 дугаар улиралд тусгахаар ажиллаж байна.

Төрийн албан хаагч бид бүхэн Төрийн аудитын байгууллагаас өгч байгаа дүгнэлт зөвлөмжийн дагуу УТХО-ын төсөл арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх чиглэлээр бүх талаар анхаарч Холбогдох арга хэмжээг авч ажиллаж байгаа бөгөөд цаашид ч илүү анхаарч үр дүнтэй ажиллах болно.

ЗАСАГ ДАРГА



М.ИДЭРБАТ



СҮХБААТАР АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР
22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас, факс: 70518605, 70512605

2024.04.24 № 02/140

танай _____-ны № _____-т

"СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР"-т

Санал хүргүүлэх тухай

Сүхбаатар аймагт 2023 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний хүрээнд хийгдсэн аудитын тайлангын төсөлтэй танилцаж дараах саналыг хүргүүлж байна.

Барилга байгууламжийн архитектур төлөвлөлтийн даалгаварыг боловсруулж батлах эрх нь манай байгууллагын даргад 2023 оны 07 сард ирсэн. Бид цаашид дүгнэлтэд дурдсан зөрчил дутагдлыг гаргахгүй байх арга хэмжээг авч ажиллана.

Дарьганга сумын 150 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилгын хөрөнгө нь 4 жил дамжин батлагдсан. Барилгын талбайд хийх хана, хамар хана, багана дамнурууны шавардлах ажил хийхээр төлөвлөж бараа материал буусан байсан боловч, барилга угсралтын ажил технологийн зогсолт хийх нөхцөл байдал тулгарсан. Тухайн барилга угсралтын ажлын гүйцэтгэгч байгууллага нь 2023 онд тухайн үеийн гэрээний нөхцөлд тусаагүй цахилгааны дэд станцын өргөтгөлийн ажлыг тус сум эрчим хүчний тасралт үүсэх эрсдэлтэй үед хийж гүйцэтгэн сумын цахилгаан эрчим хүч хэрэглэгчидийг найдвартай эх хүүсвэртэй болгосон. /хуучин 250 кВа дэд станц, 2 тулгууртай, 4 гаргалгаатай байсныг, 400 кВа дэд станц, 3 хөлтэй, 6 гаргалгаатай, шинэ самбартай КТПН болгон өргөтгөсөн/. Тус барилгын үлдэгдэл санхүүжилт 2024 оны Улсын төсөвт батлагдаж ажил үргэлжлүүлэн гүйцэтгэх гэрээ хийгдсэн болно.

Спорт цогцолборын барилга угсралтын ажил нь гадна тохижилт, ногоон байгууламжийн ажлыг 2023 онд хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн боловч хүйтний улиралд хийлгэхгүйгээр зогсоосон. Тухайн барилга угсралтын ажил 2023 оны өвлийн улиралд зогсолт хийхгүйгээр дулаанд холболт хийж дотор ажлуудыг хийж гүйцэтгэн дуусгах шатанд үргэлжилж байна. Өнөөдрийн байдлаар тус барилгын гадна тохижилтын ажлын гүйцэтгэл эрчимтэй хийгдэж байна.

Соёл амралын хүрээлэнгийн барилга угсралтын ажил 2023 оны өвөл технологийн зогсолт хийх шаардлагагүй ажлуудыг хийж гүйцэтгэн барилга угсралтын ажил үргэлжилж байна. Тус барилга угсралтын ажлын дугуйн зам, авто зогсоолын хашлагууд, зогсоолын тэмдэг хийх материал эдлэхүүн ажлын бууж угсралтын ажил хийх бэлтгэл хангагдаж байна.

Баруун-Урт сумын 960 хүүхдийн сургуулийн барилга, Түвшинширээ сумын 100 ортой дотуур байрны барилга угсралтын ажлуудад илэрсэн зөрчлийг гүйцэтгэгч, захиалагч, зохиогч байгууллагуудтай зөвшилцөн шийдэл гаргуулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Ашиглалтад орсон барилга байгууламжид илэрсэн зөрчил дутагдлыг арга хэмжээ авч ажиллах талаар гүйцэтгэгч байгууллагуудад хугацаатай албан шаардлагууд хүргүүлсэн. Арга хэмжээ авч ажиллагаагүй тохиолдолд чанарын баталгааны хөрөнгийг суллахгүй байх талаар арга хэмжээ авч, тусгай зөвшөөрөл олгогч байгууллагад хандахыг мэдэгдсэн болно.

Баяндэлгэр сумын 300 суудалтай Соёлын төвийн барилга, Дарьганга сумын Дарьганга зуслан орчин үеийн стандартад нийцсэн аялал жуулчлалын цогцолбор болгон шинэчлэх төсөл арга хэмжээний гүйцэтгэгч байгууллагуудтай 2023 оны 01 дүгээр сард захиалагч, гүйцэтгэгчтэй уулзалт хийхэд манай байгууллагын зүгээс тус 2 барилгын гүйцэтгэгчээс татгалзах санал оруулсан боловч дэмжигдээгүй, гүйцэтгэгч байгууллагууд тус онд ажил огт хийгдээгүй тул гэрээг цуцлах ажлыг яаралтай арга хэмжээ авч ажиллана.

Манай байгууллагын бүтэц орон тоонд 2023 оны 01 сард барилга техникийн хяналтын Улсын байцаагчийн орон тоо батлагдан ирсэн. Орон тоо батлагдсан даруй аймгийн төрийн албаны зөвлөлд удаа дараа зарлуулсан боловч тусгай шалгалтад хүн ороогүй улмаас орон тоо сул байна.

Манай байгууллага 2024 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутагт хэрэгжих төсөл арга хэмжээний ажлуудад захиалагчийн хяналт хэрэгжүүлэх гэрээт инженер техникийн ажилтан авах бэлтгэл ажлыг судлан ажиллаж байгаа болно.

ХЭЛТСИЙН ДАРГА  Г.ЭНХЖИН



Ирүүлсэн саналд өгсөн тайлбар:

Аймгийн Засаг даргаас ирүүлсэн саналд дараах тайлбарыг өгч байна. Үүнд:

Тайлбар 1	1.1.3.-тай холбоотой саналд өгөх тайлбар: ЗГ-ын 2021 оны 160-р ТОГТООЛЫН 2.3.2.5-д /барилга байгууламжийн зураг төслийн үнэ, захиалагчийн хяналтын зардал, зохиогчийн хяналтын зардал, нормчлолын сангийн зардал, чанарын баталгаат хугацааны барьцааг тус тусын дансанд холбогдох баримт бичиг, тоног төхөөрөмж хүлээн авсан акт зэргийг үндэслэн шилжүүлэх;/ ГЭЖ заасан, мөн ЗГ-ын 2023 оны 278-р ТОГТООЛЫН 4.2.2.5-д /"төсөл, арга хэмжээний техник, технологийн хяналтын зардал болох захиалагчийн хяналт, зохиогчийн хяналтын зардлыг захиалагчийн техник хяналтын дансанд, чанарын баталгаат хугацааны барьцаа буюу ашиглалтад тохируулах, зүгшрүүлэх хугацааны санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд, зураг төслийн үнэ, нормчлолын сангийн зардлыг тус тусын дансанд холбогдох гэрээ, баримт бичиг, акт зэргийг үндэслэн шилжүүлэх"/ гэж заасан тул нормчлолын сангийн зардлыг тус тусын дансанд холбогдох гэрээ, баримт бичиг, акт зэргийг үндэслэн шилжүүлэх тул саналыг хүлээн авах боломжгүй байна.
Тайлбар 2	1.2.1-тэй холбоотой саналыг хүлээн авч тайланд өөрчлөлт оруулсан.
	Бусад тайлбарын хувьд тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

Аймгийн ГХБХБГ-аас ирүүлсэн саналд тайлбар байхгүй.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Архитектур төлөвлөлтийн даалгаврыг "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм"-ийн дагуу боловсруулаагүй, төсөл арга хэмжээний төсөвт өртгийг улсын төсөвт бүрэн тусгаагүйгээс зарим төсөл арга хэмжээ удаашрах, дуусахгүй орхих эрсдэлүүд үүсэж байна.
2. Гүйцэтгэгчээс шалтгаалж барилгын ажил гүйцэтгүүлэх гэрээг цуцлах нөхцөл байдал үүссэн 2 төсөл арга хэмжээ байгаа бөгөөд улсын комисс хүлээн авсан барилгуудад дээврээс ус гоожих, дулаан алдагдал ихтэй байх зэрэг зөрчил нийтлэг гарч байна.
3. Зарим төсөл арга хэмжээний бодит гүйцэтгэлийг 601.2 сая төгрөгөөр илүү дүнгээр баталгаажуулж, санхүүжилтийг олгосон бөгөөд төсөл, арга хэмжээний хэрэгжилттэй холбоотой зөрчил байгаа нь бүх шатны хяналт үр нөлөөгүй байгааг илтгэж байна.
4. Барилга, байгууламжийг байнгын ашиглалтад оруулах комиссоос өгсөн үүрэг даалгавар, гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгч нартай хариуцлага тооцох, гэрээг цуцлах шаардлага үүссэн байна.
5. Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл нь Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3 дахь заалттай нийцээгүй, данс бүртгэлд бүрэн тусгаагүй байна.

6. Ашиглалтад орж бүртгэлд тусгасан төсөл арга хэмжээний материалын үнийн өсөлтийг тооцож Төсвийн тухай хуульд нэмж тусгасан дүнгээр капиталжуулж бүртгэлд тусгаагүй, баригдаж дууссан барилгыг бүртгэлд тусгах Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоол гараагүй тул АИТХ-аар хэлэлцүүлээгүй байна.
7. Хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн түрээсийн орлогын төвлөрүүлэлтийг эс тооцвол барилгын байгууламжийн төсөл, арга хэмжээнүүд төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитаар өгсөн дүн дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

Аймгийн Засаг даргын тамгын газарт:

1. "Шинэ хөдөө" төслийн хүрээнд нийлүүлэгдсэн 25 толгой бух, Тукан НР маркийн 2 ширхэг өвс хаман боогчийг данс бүртгэлд тусгах.

Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтэс болон Газрын харилцаа барилга хот байгуулалтын газарт:

1. Төсөл арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгож, дотоод хяналтыг сайжруулах, гүйцэтгэлийг бодитоор хянан баталгаажуулаагүй, буруутай албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах асуудлыг хуульд заасны дагуу тухай бүр шийдвэрлэж байх.
2. Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт барилгын хэлтэст хяналт хийхэд хүрэлцэхүйц тооны гэрээт ажилтнуудыг авах, тэдгээрийн цалин, холбогдох бусад зардлыг захиалагчийн техник хяналтын зардлаас санхүүжүүлж, хяналтын чанар, үр нөлөөг дээшлүүлэх.
3. Ашиглалтад хүлээн авсан барилгууд чанаргүй байх эрсдэлийг хаах үүднээс гүйцэтгэлийн баталгаа болон чанарын баталгаат хугацааны барьцааг улсын комиссоос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй тохиолдолд чөлөөлөхгүй байх.
4. Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт барилгын хяналтын улсын байцаагчийн сул орон тоон дээр Төрийн албаны тухай хуульд заасны дагуу хүн авч ажиллуулах талаар холбогдох арга хэмжээг үр нөлөөтэй зохион байгуулах, Барилгын тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан техникийн улсын хяналтыг хэрэгжүүлэх.

Сүхбаатар аймгийн Орон нутгийн өмчийн газарт:

1. Хэрэгжиж дууссан болон материалын үнийн өсөлтийг тооцож Төсвийн тухай хуульд нэмж тусгасан дүнгээр капиталжуулж бүртгэлд тусгаагүй төсөл, арга хэмжээг холбогдох байгууллагуудын данс бүртгэлд тусгах ажиллагааг тайлант онд нь багтаан шийдвэрлүүлэх.

2. "Шинэ хөдөө" төслийн хүрээнд нийлүүлэгдсэн өвс хаман боогч болон хүлэмжийг иргэн, аж ахуйн нэгжид түрээслүүлэх гэрээний 4.1.4 дэх заалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 3-т нийцүүлж, гэрээнд өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулах.
3. Аймгийн Засаг даргын захирамжаар 130 ширхэг notebook-ийг байгууллагуудад олгохоор хуваарилагдсанаас данс бүртгэлд тусгаагүй 13 notebook-ыг хуваарьт байгууллагуудын дансанд тусгуулах

Үндэсний аудитын газарт хүргүүлж буй санал:

1. Газар эзэмших эрхийн гэрчилгээгүй төсөл арга хэмжээний зураг төсвийг магадлалаар оруулж, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний жагсаалтад батлагдсан нь Барилгын тухай хуулийн 12.1, 12.1.1 дэх заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 3, 13.3.3 дахь заалтыг зөрчиж байгааг холбогдох яам, албан тушаалтанд уламжлах.
2. Барилгын төсөвт магадлал хийх үе шатанд "Барилгын төсөв зохиох дүрэм"-ийн 5.10-т заасан тоног төхөөрөмжүүдийг материалын зардлын тооцоонд тусгасан эсэхийг хянуулах, дүрмийн хэрэгжилтийг хангуулах талаар холбогдох байгууллагад уламжлах.
3. Барилгын захиалагчийн техникийн хяналт болон зохиогчийн хяналт хэрэгжүүлэх субъектүүд барилгын ажлын бүх үе шатанд барилгын норм, дүрмийн хэрэгжилтийг хянаж, шалгахад зарцуулбал зохих хугацааны доод хэмжээг барилгын төсөвт өртгийн хэмжээтэй уялдуулан хүн/өдрөөр тооцон нормчилж, холбогдох заалт, зохицуулалтыг "Барилгын ажлын захиалагчийн дүрэм" болон "Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм"-д тодорхой тусгах нь зүйтэй байна.

Тайлан бичсэн:

Хянасан:

Ахлах аудитор

Г.Оюунболд

Дарга, тэргүүлэх аудитор

Аудитор

Э.Алтансүх

Г.Даваа

Б.Ганцэцэг

Аудитын менежер

М.Нарантуяа

---oOo---